



ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ НАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны III байр  
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09  
E-mail: ub\_info@inspection.gov.mn  
http://www.ub.inspection.gov.mn

2014. 02. 20 № 02-01/613  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлагыг дагаж мөрдөхгүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийдэггүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний төсөв, зардлыг баталж, мөрдүүлдэггүй, машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллаагүй зэргээс шалтгаалан үйлдвэрлэлийн осол гарч, иргэд эрүүл мэнд, эдийн засгаараа хохирсоор байна.

Иймээс тус чиглэлээр үйлдвэрлэл явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын эзэн, захирал, ажил олгогч нарт дараахь заалтуудыг мөрдөн хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдэж байна. Үүнд:

1. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 9.1.1-9.1.4 дэх заалт /машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх/,
2. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 9.3 дахь заалт /Цахилгааны тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байх/,
3. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 15.1 дэх заалт /ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах/,
4. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 17.1, 17.2.1-17.2.3 дахь заалт /Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулсан байх/,
5. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 26.2 дахь заалт /аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулах/.

1150500315

6. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 27.1 дэх заалт Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцах/,

7. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 28.1.4 дэх заалт /ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх/,

8. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 28.2.2 дахь заалт /хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний төсөв, зардлыг баталж, хэрэгжүүлэх/,

9. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 29.1 дэх заалт /Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн, ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах, осол, хурц хордлогын хор уршгийг арилгах арга хэмжээг 24 цагийн дотор авах/,

10. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 35.1 дэх заалт /Ажил олгогч нь үйлдвэрлэлийн цех, тасаг, хэсэг, ажлын байр бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавих/

Дээрхи заалтуудыг мөрдөн ажиллаагүй тохиолдолд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 36 дугаар зүйл, "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахыг мэдэгдэж байна.

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА БӨГӨӨД УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Д.ЭРДЭНЭЧУЛУУН

